

ДУНДГОВЬ АЙМАГ
“САНХҮҮЛ БАЯН УУЛ-АУДИТ” ХХК

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ГСА-2018/24/СТА-ТШЗ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН “3 ДУГААР СУРГУУЛЬ”-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**(2017 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон)**

2018 он



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

**ШИВЭЭГОВЬ СУМЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Б.ЭНХРИЙМАА ТАНАА**

2018.02.25 № ТЗА-2018/24/СТА-ТМБ
танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шивээговь сумын "3 дугаар сургууль"-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй

.. 080114

нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

Асуудал 1: Анхан шатны маягт хөтлөлтийн
ТАЛААР

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №01

Илрүүлэлт

Цагийн балансыг бүрэн хөтлөөгүйгээс ажилтан амарсан, өвдсөн, чөлөөтэй эсэх нь тодорхойгүй байгаа нь тулган баталгаажуулалт хийхэд хүндрэлтэй байлаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан



Б.Энхриймаа
Д.Пүрэвням

Эрсдэл

Нотлох баримт хангалгүй байх нь төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах

Зөвлөмж

Цагийн бүртгэл, цагийн балансыг маягтын дагуу үнэн зөв хөтөлж, тухай бүр шалгаж, баримтыг бүрдүүлж байх

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга
Нягтлан



Б.Энхриймаа
Д.Пүрэвням

Асуудал 2: Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №02

Илрүүлэлт

Тус байгууллагын авлагын эхний үлдэгдэл 392.4 мянган төгрөг нь үүссэн цагаас хойш 5 жил болсон бөгөөд барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, урьдчилж гарсан зардал өмнөх оноос 9,580.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Хариуцах ажилтан

Дарга
Нягтлан



Б.Энхриймаа
Д.Пүрэвням



Зөвлөмж

1. Олон жил болсон авлагын эзэн холбогдогчийг тодруулж, барагдуулах талаар ажил зохион байгуулж, асуудлыг шийдвэрлэх
2. Төсвийн хөрөнгөөр хууль тогтоомж зөрчиж сан байгуулахгүй байх

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал алдагдах


Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн

Дарга
Нягтлан



Б.Энхриймаа
Д.Пүрэвням



Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургууль

Аудитын зөрчлийн нэгтгэлийн хүснэгт

Тайлант он: 2017

/мянган төгрөг/

Д Д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа			Нийт зөрчил			Нийт алдаа зөрчил
		Нийт дүн	Залруулсан	Залруулагда агүй	Нийт дүн	Акт	Албан шаардлага	
1	Ээлжийн амралтын цалин 180.9 мянган төгрөгөөр давхардуулан олгосон	-			180.9	180.9		180.9
2	Орон тоо дутуу ажилласнаас хэмнэсэн цалингийн сангаас 8,000.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн	-			8,000.0	8,000.0		8,000.0
3	Нэмэлт санхүүжилтийн данснаар орж ирсэн ахмадын сангийн санхүүжилт 1,140.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд дутуу бүртгэсэн	1,140.0	1,140.0		-			1,140.0
4	40 ажилтаны амралтын цалингаас ХХОАТ-ын 7.0 мянган төгрөгийн хөнгөлөлт эдлүүлээгүй, нийт 280.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй байна.	280.0	280.0		-			280.0
Дүн		1,420.0	1,420.0	-	8,180.9	8,180.9	-	9,600.9

Бэлтгэсэн: Гэрээт аудитор :

Анхан шатны хяналт хийсэн: Аудитын менежер :

Аудитын менежерийн санал:.....*Самалцэ*.....

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Тэргүүлэх аудиторовын санал:.....

Д.Оюунбат
Д.Оюунбат*Г.Наранбаяр*
Г.Наранбаяр*Б.Сарантуяа*
Б.Сарантуяа